



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/391

Ховд

Зарим үйл ажиллагааг цуцалж,  
хориглолт тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Онцгой комиссын 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоол зэргийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Өлгий аймагт малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан Ховд аймгийн Жаргалант суманд зохион байгуулахаар төлөвлөж байсан Урианхай сурын улсын аварга шалгаруулах тэмцээнийг тодорхойгүй хугацаагаар цуцалж, аймгийн хэмжээнд нийтийн аюулгүй байдал, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хурдан морины уралдаан, үсэргээ сунгаа зохион байгуулахыг түр хугацаагаар хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга (хурандаа Г.Нэргүй), Цагдаагийн газрын дарга (дэд хурандаа Ш.Сүхтулга), аймгийн Сурын холбооны тэргүүн (Г.Ганзориг), аймгийн Морины комиссын тэргүүн (Б.Ерөөлт) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА